



**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2020 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 4/320

Улаанбаатар хот

Г Шуурхай зохион байгуулалтын тухай арга хэмжээ авч ажиллах тухай

Коронавируст халдварт /COVID-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4 дэх хэсэг, Улсын онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны 12 дугаар тогтоол, Нийслэлийн Онцгой комиссын 2020 оны 15 дугаар хурлын тэмдэглэл, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/146 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/1241 дүгээр захирамж, МУИС-ийн Дүрмийн 4.3.1, 8.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Шинэ төрлийн коронавирусын дэгдэлт дэлхийн улс орнуудад хурдтай тархаж байгаатай холбогдуулан МУИС-ийн хэмжээнд халдвараас урьдчилан сэргийлэх, хамгаалах үүрэг бүхий Шуурхай багийн бүрэлдэхүүн, нэгж тус бүрд ажиллах ажилтнуудын ажиллах цагийн хуваарийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2. 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 16-ны өдрийг дуустал хугацаанд МУИС дээр нийтийг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулахгүй байхыг шуурхай багийн бүрэлдэхүүн, бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал, нэгжийн удирдлагуудад даалгасугай.

3. Хичээл сургалтын үйл ажиллагааг түр зогсоосон хугацаанд сургалтын үйл ажиллагааг цахим хэлбэрээр сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сургалт, оюутан хариуцсан дэд захирал /Д.Бадмаанямбуу/, бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал /Д.Заяабаатар, Д.Бямбажав, Ж.Эрдэнэбулган, Ч.Энхбаяр, С.Баттулга, Т.Энх-Амгалан, Д.Алтанхуяг/ нарт тус тус үүрэг болгосугай.

4. Сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх удирдамжийг 2 дугаар хавсралтаар, болзошгүй нөхцөл байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамжийг 3 дугаар хавсралтаар, шуурхай арга хэмжээний хүрээнд гарах нэмэлт зардлын төсвийг 4 дүгээр хавсралтаар тус тус баталж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг дэд захирал /Д.Бадмаанямбуу, Ч.Лодойравсал, Б.Энх-Амгалан/, бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал /Д.Заяабаатар, Д.Бямбажав, Ж.Эрдэнэбулган, Ч.Энхбаяр, С.Баттулга, Т.Энх-Амгалан, Д.Алтанхуяг/ нарт тус тус даалгасугай.

5. Шуурхай арга хэмжээний үед илүү цагаар ажиллаж байгаа ажилтнуудад хууль, журмын дагуу илүү цагийн хөлс бодож олгохыг Санхүү, төлөвлөлтийн газрын дарга /Б.Энхцэцэг/-д зөвшөөрсүгэй.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Шуурхай багийн гишүүд болон Захиргаа, хүний нөөцийн газрын дарга /Г.Мөнхбаяр/ нарт тус тус үүрэг болгосугай.


ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ОЧИРХУЯГ

3340302964

Захирлын 2020 оны дүгээр сарын 11-ны
өдрийн дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



ШУУРХАЙ БАГИЙН ГИШҮҮДИЙН ЖИЖҮҮРИЙН ХУВААРЬ

№	Овог нэр	Албан тушаал	Жижүүр хийх өдөр
1	Б.Энх-Амгалан	Санхүү, төлөвлөлт хариуцсан дэд захирал	2020.11.11
2	Б.Энхцэцэг	Санхүү, төлөвлөлтийн газрын дарга	2020.11.12
3	Ч.Лодойравсал	Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа хариуцсан дэд захирал	2020.11.13
4	Г.Мөнхбаяр	Захиргаа, хүний нөөцийн газрын дарга	2020.11.14
5	В.Алтансүх	Хангамж үйлчилгээний газрын дарга	2020.11.15
6	Д.Бадмаанямбуу	Сургалт, оюутан хариуцсан дэд захирал	2020.11.16

№	Овог нэр	Албан тушаал	Жижүүр хийх өдөр
1	Ч.Байгалмаа	СТГ. Ахлах нягтлан бодогч	2020.11.11-2020.11.13
2	Б.Мөнгөн-Од	СТГ. Ахлах нягтлан бодогч	2020.11.11
3	Б.Тамир	СТГ. Эдийн засагч	2020.11.11-2020.11.13

Захирлын 2020 оны ... дүгээр сарын -ны
өдрийн ... дугаар тушаалын 2 дугаар хавсралт

1117144746
УХД0072 9104399

СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХ УДИРДАМЖ

НЭГ. Сургалтын үйл ажиллагаатай холбоотой зарим зохицуулалт

1.1 Сургалтын үйл ажиллагаа

- 1.1.1 Лекц, семинарын хичээлийг 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 14-ний өдрийг хүртэл цахим хэлбэрээр сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.
- 1.1.2 Лабораторийн хичээлийг боломжтой тохиолдолд цахимаар явуулна.

1.2 Дадлага

- 1.2.1 Мэргэших, багшлах, үйлдвэрлэлийн дадлагыг холбогдох газруудад үргэлжлүүлэн зохион байгуулна.

ХОЁР. Оюутны дотуур байртай холбоотой зарим зохицуулалт

2.1 Оюутны дотуур байр, нийтийн эзэмшлийн талбай, амрах өрөө, ариун цэврийн өрөөнд амны хаалтыг тогтмол зүүх .

- 2.2 Дотуур байрны орж гарах хөдөлгөөнийг 19:00 цагаас хойш хязгаарлах.
- 2.3 Онц шаардлагагүй бол байрнаас гарахгүй байх, зайлшгүй шаардлагаар гарах тохиолдолд гарсан орсон цаг болон явсан маршрутаа байрны жижүүрт тэмдэглүүлэх.
- 2.4 Дотуур байранд оршин суугч байрны ариун цэвэр, ариутгал, халдвартгуйжүүлэлтийн журмыг сахин амьдрах.

- 2.5 Эрүүл мэнддээ анхаарч ханиалгах, халуурах зэрэг шинж тэмдэг зовиур илэрсэн тохиолдолд МУИС-ийн эмчид хандах ба 119 дугаарт дуудлага өгөх.
- 2.6 Гараа тогтмол савандаж угаах, ариутгах.
- 2.7 Ханиаж найтаах үедээ амны цаас, алчуур хэрэглэх.
- 2.8 Амны хаалт тогтмол хэрэглэх.
- 2.9 Өрөө тасалгаанд тогтмол агаар сэлгэлт хийх.

Захирлын 2020 оны ... дүгээр сарын -ны
өдрийн ... дугаар тушаалын З дугаар хавсралт

1320

1117144746
УХД0072 9104399

КОВИД-19 БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ АВАХ УДИРДАМЖ

Зорилго: 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн БОАЖС А/125, ХХААҮ сайдын А/69, ЭМС-ын А/143-р хамтарсан тушаал, ЭМС-ын 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/269, 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/537 тоот тушаалууд, MNSC 5766-2007 стандарт, ЗӨСҮТ-ийн захирлын А/15 тоот тушаал, НМХГ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэх, МУИС-ийн хичээлийн болон оюутны дотуур байранд Covid-19-ийн сэжигтэй тохиолдол гарсан үед шуурхай арга хэмжээ авах, халдвартай тархаас урьдчилан сэргийлэх.

COVID-19-ийн сэжигтэй тохиолдлын шинж тэмдэг:

- Биеийн хэм 37,1-ээс дээш халуурах, ханиалгах, амьсгаадах зэрэг амьсгалын замын цочмог халдвартай шинж тэмдгийн аль нэг илэрсэн.
- Амтлах үнэрлэх мэдрэмж буурсан.
- Эмнэл зүйн шинж тэмдэг илрэхээс өмнө COVID-19 бүртгэгдсэн улс орон нутагт аялсан, тусгаарлалтаас гарсан болон тусгаарлалтад байсан хүнтэй харьцсан, халдвартай улс орноос илгээмж хүлээн авсан, эсвэл оршин судаг гэсэн өгүүлэмжтэй байх.

Сэжигтэй тохиолдол илэрсэн үед авах арга хэмжээ:

1. Хичээлийн болон Оюутны байранд сэжигтэй тохиолдол илэрмэгц байрны зохион байгуулагчид мэдэгдэнэ.
2. Зохион байгуулагч “ШУУРХАЙ АРГА ХЭМЖЭЭ”-ний багийн ахлагчид мэдэгдэнэ.
3. Тухайн байршлын орох, гарах бүх хөдөлгөөнийг хориглож, хавьтал үүссэн байх магадлалтай хүмүүст амны хаалт зүүлгэж, 1 удаагийн бээлий өмсүүлнэ.
4. Сэжигтэй тохиолдлыг урьдчилан бэлтгэсэн тусгаарлах өрөөнд тусгаарлана. Харин оюутны дотуур байранд бол тухайн амьдарч байгаа өрөөнд нь тусгаарлана.
5. Шуурхай арга хэмжээний баг мэдээ авмагц тухайн байрны орох гарах хөдөлгөөнийг зогсоож, сургуулийн эмч болон ХӨСҮТ-ийн 100, 119 тоот утаснуудад мэдэгдэнэ.

6. Сургуулийн эмч, сувилагч нар тусгаарлагдсан өрөөнд орж үзлэг хийж, анхны тусlamж үзүүлнэ.

7. Тусгаарлах өрөөнд сэжигтэй тохиолдлыг оруулмагц урьдчилан сэргийлэх агаарын ариутгал хийнэ. Үүнд:

- Ариутгалыг хийхдээ сэжигтэй тохиолдол орж ирсэн үүд хаалганаас эхэлж хийх бөгөөд байсан анги танхимд хийснээр дуусгана.
- Ариутгалыг ХАБЭА хариуцсан мэргэжилтэн хариуцаж хийлгэнэ.
- Халдварт хамгаалалтын хувцас, улавч өмсөж, нүдний шил, N95 маск зүүж ариутгал халдвартгүйжүүлэлтийг хийж гүйцэтгэнэ.

8. Шуурхай арга хэмжээний баг сэжигтэй тохиолдолд үйлчилгээ үзүүлсэн эмч, сувилагч, нэг анги танхимд хамт байсан хүмүүсийг бүртгэнэ.

9. Тусгаарласан өрөөнд шаардлагатай болсон материал, хэрэгслийг тухайн өрөөний гадна байрлуулна.

10. ХӨСҮТ-ийн шуурхай хариу арга хэмжээний баг ирж үнэлгээ хийж, сэжигтэй тохиолдлыг авч явсны дараа ХАБЭА хариуцсан мэргэжилтэн хариуцан дахин агаарын болон эд зүйлсэд ариутгал халдвартгүйтгэлийг тухайн байрны нийт талбайд хийж гүйцэтгэнэ.

Багш, ажилтан сургууль руу нэвтрэх:

- Багш, ажилтны ажлын үнэмлэхээр сургууль руу нэвтэрч орж байх.